



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 24 болон 25 дахь долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 05-р сарын 14-өөс 05-р сарын 28-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны 8 дахь дугаарыг хүргэж байна.

1

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- ОУВС энэ оны сүүл гэхэд дэлхийн хүн амын 40 хувийг, 2022 оны 6-р сар гэхэд 60 хувийг вакцинжуулалтад хамруулахаар зорьж байгаа тухай мэдээллээ. Энэ хүрээнд **ОУВС-гаас хөгжиж буй улс орнуудын вакцинжуулалтын үйл явцыг түргэсгэхэд зориулан нэмэлт 50 тэрбум ам.долларын санхүүжилт босгохоо зарлаад байна.** Энэ нь одоо хэрэгжиж байгаа COVAX хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлэх арга хэмжээ бөгөөд 2021 оны 5-р сарын эцсийн байдлаар дэлхийн хүн амын 10.7 хувь нь вакцины эхний тундаа хамрагдаад байна. ОУВС-гийн тооцооллоор дээрх байдлаар вакцинжуулалтыг эрчимжүүлж, цар тахлыг эрт дарж авснаар 2025 он хүртэлх хугацаанд дэлхийн эдийн засагт 9 их наяд ам.долларын эерэг үр өгөөжтэй болохыг онцолжээ.
- **ХБНГУ-ын эдийн засгийн өсөлт 2021 оны 1-р улиралд өмнөх улирлаас 1.8 хувиар, өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар буурчээ.** Өрхийн хэрэглээ огцом танагдаж, худалдааны тэнцэл алдагдалтай гарсан нь өсөлтөд голлох сөрөг нөлөөг үзүүлжээ.
- **ОХУ-ын эдийн засаг 2020 оны 4-р улиралд өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар, 2021 оны 1-р улиралд 1.0 хувиар буурчээ.** Харин ажилгүйдэл өнгөрсөн оны 3-р улиралд 6.5 хувьтай байсан бол энэ оны 4-р сарын байдлаар 5.6 хувьд хүрч сайжраад байна. Тус улсын аж үйлдвэрлэлийн салбар энэ оны 1-р улиралд өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар буурсан хэдий ч 4-р сард 7.2 хувиар өссөн байна.
- Европын Төв банкны Ерөнхийлөгч дэлхийн дулаарлын эсрэг санхүүгийн системд үзүүлэх эрсдэлийг тооцоолох, ногоон бонд гаргах арга хэмжээг авч эхлээд байгаа билээ. Тэгвэл Японы Төв банкны ерөнхийлөгч Харухико Курода эдийн засгийн нөхцөл байдал, үнийн тогтвортой байдлыг хангах хүрээнд дэлхийн дулаарлын нөлөөг тооцож, холбогдох арга хэмжээг авах тухай мэдэгдэж, бусад төв банкуудыг дэлхийн дулаарлын эсрэг тэмцэхэд уриаллаа. Блүүмбергийн судалгаагаар нийт оролцогч эдийн засагчдын 83 хувь нь Японы Төв банкнаас байгаль орчныг хамгаалах зорилгоор ногоон зээлийн урамшууллыг зарлана үзэв. Түүнчлэн, ногоон зээлийн урамшууллын зорилго



нь банкуудад зээлийн хүүг бууруулах орон зайг бий болгоно гэж харж байгаа юм. Курода тус улсын инфляц зорилтот түвшин 2 хувиас доогуур байгаа тул мөнгөний зөөлөн бодлогоор 2 хувьд хүрэхээр зорьж байгаа тухай мэдэгдлээ.

- Австрали болон Их Британи улсууд чөлөөт худалдааны гэрээ хэлэлцээрийн шатандаа явж байна. Чөлөөт худалдааны гэрээ нь голчлон хонь, үхрийн мах болон хөрөнгө оруулалт, үйлчилгээний салбарыг хамрахаар байгаа тухай Австралийн худалдааны сайд мэдээллээ.

Эх сурвалж:

1. The Bank of Finland Institute for Emerging Economies, [Russian economy continues to recover](#)
2. Financial Times, [How to defend against inflation?](#)
3. CNBC, [IMF urges \\$50 billion spending commitment to help end the coronavirus pandemic](#)
4. Bloomberg, [Australia Is Still Negotiating With U.K. on Free-Trade Agreement](#)
5. Bloomberg, [Kuroda Says BOJ Will Mull Climate in Monetary Policy Discussions](#)

2

АНУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **АНУ-ын инфляц өсөх төлөвтэй.** ХҮИ-ээр хэмжигдэх инфляц энэ оны **4-р сард 4.2 хувьд хүрсэн** нь 1990 оноос хойших хамгийн өндөр түвшин юм. Мөн өмнөх сараас 0.8 хувиар өссөн нь төсөөллөөс өндөр өсөлт байлаа. Инфляц өссөн нь бонд болон үнэт цаасны зах зээлд том алдагдлыг бий болгоод байна. Учир нь инфляц өсөх нь аж ахуй нэгжүүдийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх тул Холбооны нөөцийн банкнаас мөнгөний бодлогоо чангаруулах арга хэмжээ авч болзошгүй гэж шинжээчид үзэж байна. Dow Jones Industrial Average 681.5 нэгжээр буюу 2 хувиар буурч 33,587.66 нэгжид, S&P 500 2.1 хувиар буурч 4,063.04 нэгжид, Nasdaq 2.7 хувиар буурч 13,031.68 нэгжид тус тус хүрсэн нь 1 дүгээр сараас хойших огцом уналт болоод байна. Харин Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж 1.61 хувьд хүрч нэмэгдсэн бол АНУ-ын мөнгөний нийлүүлэлт 2020 оны 2-р сараас хойш 26 хувиар өссөн байна. Холбооны нөөцийн банкны нарийн бичгийн дарга Жанет Еллэн инфляц **2021 оны туршид өсөх хандлагатай** байна гэж мэдэгдлээ.
- АНУ-ын Ерөнхийлөгч **Жоэ Байден 2022 оноос эхлэн хэрэгжих 6 их наяд ам.долларын төсвийн багц хөтөлбөрийн төслийг** танилцуулахаар боллоо. Уг багц хөтөлбөр нь дундаас доош орлоготой айл өрхийн амьжиргааг дээшлүүлж, дундаж давхаргад оруулах, АНУ-ын үйлдвэрлэлийн салбарыг сайжруулах зорилготой ажээ. Дээрх төсвийн дийлэнхийг боловсрол, эрүүл мэнд, дэлхийн дулаарлын эсрэг хөрөнгө оруулалтууд болон дэд бүтцийн салбарт зарцуулахаар байгаа нь Дэлхийн II дайнаас хойшхи томоохон зарцуулалтад тооцогдож байна. New York Times-ийн тооцооллоор 2031 оныг хүртэл төсвийн зарцуулалт **8.2 их наяд ам.долларт хүрч, төсвийн алдагдал 1.3 тэрбум ам.долларт** хүрэхээр байна. Төсвийн зарцуулалтыг ийнхүү нэмэгдүүлэхийн тулд Жоэ Байден корпорацуудын болон 400 мянган ам.доллараас дээш орлоготой иргэдийн татварыг нэмэгдүүлэх санал дэвшүүлээд байгаа аж.
- **АНУ-ын үл хөдлөх хөрөнгийн эрэлт өсч, нийлүүлэлт буурав.** АНУ-ын ерөнхийлөгч Жоэ Байден 300 тэрбум



ам.долларын хөрөнгө оруулалтыг үл хөдлөх салбарыг дэмжихэд зарцуулахаар болсон билээ. Түрээсийн төлбөр болон моргежийн чанаргүй зээлдэгчдэд зориулсан нэмэлт 50 орчим тэрбум ам.долларыг АНУ-ын Конгресс батлаад байна. Дээрх арга хэмжээнүүд нь сайн түүхтэй зээлдэгчдэд илүүтэй нөлөөлж, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн дахин санхүүжилт нэмэгдэх, иргэд хоёр дахь үл хөдлөхөө худалдан авах хандлага нэмэгдэж байна. Түүнчлэн, Холбооны нөөцийн банкны мөнгөний зөөлөн бодлогын нөлөөгөөр моргежийн хүү **2.59-2.95 хувийн**

хооронд хэлбэлзэж байна. Харин мэднэ нийлүүлэлт буурсан нь барилгын салбарын нийлүүлэлт буурахад гол нөлөөг үзүүлээ.

Эх сурвалж:

1. NY Times, [Biden to Propose \\$6 Trillion Budget to Make U.S. More Competitive](#)
2. Bloomberg, [America has a housing mess](#)
3. CNBC, [Dow tumbles 680 points in worst decline since January as hot inflation reading spooks investors](#)

3

БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **БНХАУ-ын үндсэн хөрөнгийн (fixed asset investment) хөрөнгө оруулалт** 2021 оны эхний 4 сард 14.4 их наяд юаниар буюу жилийн 19.9 хувиар өсчээ.
 - Эдийн засгийн идэвхжлийг даган хувийн сектор дэх хөрөнгө оруулалт 8.25 их наяд юаниар буюу өмнөх оны мөн үеэс 21.0 хувиар өсөв.
 - Боловсруулах үйлдвэрлэлийн салбар дахь хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 23.8 хувиар өсөв.
 - Дэд бүтцийн барилга байгууламжийн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 18.4 хувиар тус тус нэмэгдлээ.
- **БНХАУ-ын дотоодын үл хөдлөх салбарын хөрөнгө оруулалт** 2021 оны эхний 4 сард 4.0 их наяд юань хүрч жилийн 21.6 хувиар өссөнөөс орон сууцны хөрөнгө оруулалтын тэлэлт үргэлжилж, жилийн 24.4 хувиар өсч, 3.02 их наяд юаньд хүрлээ.
- **Автомашин** худалдаа 2021 оны эхний 4 сард 8.75 саяд хүрч, жилийн 51.8 хувиар нэмэгдсэн бол автомашин үйлдвэрлэл эхний 4 сард 8.66 саяд хүрч жилийн 53.4 хувиар нэмэгдэв. Үүнээс зөвхөн 4-р сард 2.2 сая автомашин

үйлдвэрлэсэн нь өмнөх сараас 9.7 хувиар буурсан хэдий ч өмнөх оны мөн үеэс 6.8

хувиар өссөн үзүүлэлт болжээ. Мөн автомашины худалдаа 4-р сард жилийн 8.6 хувиар өсч 2.25 сая нэгж борлуулагдсан нь өмнөх сараас 10.8 хувиар буурсан дүн юм.

- **БНХАУ-ын Монголоос импортолсон коксжих нүүрсний хэмжээ 2021 оны эхний 4 сард 6.7 сая тонн буюу өмнөх оны уналтаас 91.4 хувиар өндөр байгаа хэдий ч ... сараас эхэлсэн зогсонги байдал бүрэн сэргээгүй байна.** Мөн хугацаанд БНХАУ-ын Канадаас импортолсон коксжих нүүрсний хэмжээ 49.7 хувиар өсч 2.6 сая тоннд, ОХУ-аас импортолсон коксжих нүүрсний хэмжээ 14.0 хувиар өсч, 2.2 сая тоннд хүрсэн бол **Австралиас коксжих нүүрс импортлоогүй** байна.
- **БНХАУ-ын гангийн импорт 2021 оны 4-р сард жилийн 15.8 хувиар өсч 1.17 сая тоннд хүрсэн бөгөөд оны эхний 4 сарын байдлаар жилийн 17 хувиар өсч, 4.9 сая тоннд хүрчээ.**



- БНХАУ-ын дотоод эдийн засгийн идэвхжил хадгалагдан, аж үйлдвэрлэлийн салбар дахь ашигт ажиллагаа 2021 оны 4-р сард өмнөх оны мөн үеэс 57 хувиар нэмэгдсэн хэдий ч өмнөх сартай харьцуулахад буурчээ. Үүнд:
 - Аж үйлдвэрлэлийн салбарын ашиг энэ оны 3-р сард жилийн 92.3 хувиар өссөн бол 4-р сард суурь үеийн нөлөөгөөр өсөлт саарч, жилийн 57 хувиар өслөө. Аж үйлдвэрлэлийн салбар дахь компаниудын ашиг 2020 оны 3-р сард жилийн 34.9 хувиар, 4-р сард жилийн 4.3 хувиар буурч байсан юм.
 - Аж үйлдвэрлэлийн салбар дахь үйлдвэрлэл энэ оны 3-р сард жилийн 14.1 хувиар өссөн бол 4-р сард өсөлт саарч, жилийн 9.8 хувь байв. Түүнчлэн тус салбарын ашигт ажиллагаа 2021 оны 1-р улиралд өмнөх оны мөн үеэс 158 хувиар нэмэгдэж байсан бол оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс 114 хувиар нэмэгдэв.
 - Уул уурхайн үйлдвэрлэлийн ашигт ажиллагаа 2021 оны 1-р улиралд өмнөх оны мөн үеэс 77 хувиар нэмэгдсэн бол оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс 103 хувиар өсөв.
 - Үйлдвэрлэгчийн үнийн өсөлт хурдтай нэмэгдэж байна. Тухайлбал, Үйлдвэрлэгчийн үнийн PPI индекс 3-р сард жилийн 4.4 хувиар өссөн бол 4-р сард түүхий эдийн өндөр үнийн нөлөөгөөр жилийн 6.8 хувиар өсөв. Түүхэн тоон өгөгдлөөс харахад PPI үнийн индекс нь ашигт ажиллагаатай илт эерэг хамааралтай байгааг Блүүмберг Экономиксийн шинжээчид онцолж байна.
 - Экспортын идэвхжил нэмэгдсэн нь ашигт ажиллагаанд мөн эерэгээр нөлөөлөв. Экспорт 2021 оны 3-р сард жилийн 30.6 хувиар, 4-р сард жилийн 32.3 хувиар өсч, өсөлт нь эрчимжлээ.
 - Харин өмчлөлийн хэлбэрээр авч үзвэл, төрийн өмчит болон гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын ашигт ажиллагаа оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс 187 хувь, 107 хувиар тус тус нэмэгдсэн бол хувийн сектор дахь компаниудын ашигт ажиллагаа өмнөх оны мөн үеэс 69 хувиар нэмэгдэв.
- Гашуунсухайт боомт дээр түр хугацаанд “Ногоон гарц” журмын хэрэгжүүлж эхэлснээр уг боомтоор нэвтрэх нүүрсний тээврийн машины тоо 4-р сард өдөрт дунджаар 50 байсан бол 5-р сарын 31-ний байдлаар 176 болж нэмэгдээд байна. Харин дотоодод тархалт эргээд нэмэгдэж байгаагийн улмаас БНХАУ-ын талаас 6-р сарын 1-ээс эхлэн Шивээхүрэн боомтоор нэвтрэх автомашины тоог өдөрт 200 байсныг 90 болгож бууруулаад байна. Тус боомтоор 4-р сард өдөрт дунджаар 89 машин, 5-р сард өдөрт дунджаар 140 машин нэвтэрчээ.

Эх сурвалж:

1. *China Preview: Double-Digit industrial profit gains likely eased, Bloomberg*
2. *China React: Uneven profits growth brews inflation pressure, Bloomberg*
3. *China Coal/Coal Market Monthly, May 2021, sxcoal.com*

4

ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бодит гүйцэтгэл							
	Үнэ (-1 day) 2021/04/28	Өөрчлөлт					Товч тайлбар
		daily	weekly	monthly	year to date	YoY	
Зэс	9961	2.4%	2.3%	3.5%	31.7%	95.2%	КОВИД-19-ийн халдварын тархалт зарим орнуудад эрчимжиж байгаа ч улс орнуудад вакцинжуулалт үргэлжилж буй нь зах зээлд оролцогчдын итгэлд эерэгээр нөлөөлж байна. Дэлхийн эдийн засгийн сэргэлт үргэлжилж, БНХАУ-д болж өнгөрсөн баяр наадмын дараа эрэлт нэмэгдсэн зэрэг нь зэсийн үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс нэмэгдэхэд нөлөөлөв.
Төмрийн хүдэр	195	0.0%	-10.6%	5.5%	27.2%	112.0%	БНХАУ энэ онд барилгын салбараа эрчимтэй дэмжих хүлээлтийн улмаас төмрийн хүдрийн эрэлт хадгалагдах төлөвтэй. Харин БНХАУ-ын хил дээрх нөөц өмнөх долоо хоногоос нэмэгдсэн нь үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс буурахад нөлөөлөв.
Алт	1897	0.0%	1.4%	6.8%	-0.1%	10.9%	Хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа нь алтны эрэлт, үнэ өндөр байхад нөлөөлж байна. АНУ-ын 10 жилийн бондын өгөөж буурснаар алтны үнэ өмнөх долоо хоногоос бага зэрэг нэмэгдлээ.
Газрын тос (Брент)	68.8	0.9%	4.2%	4.6%	36.0%	99.9%	ОПЕК+-ийн нэгдэл нийлүүлэлтээ хүлээлтээс бага хэмжээгээр өсгөхөөр шийдвэрлэсэн, БНХАУ, АНУ-ын эдийн засгийн суурь үзүүлэлтүүд сайн гарсан нь газрын тосны үнийг өмнөх долоо хоногоос өсгөх чиглэлд нөлөөлж байна. Түүнчлэн, ОПЕК+-ийн нэгдэл энэ онд газрын тосны эрэлт 6.6 хувиар нэмэгдэх төсөөлөлтэй байгаа нь үнийг өсгөх чиглэлд нөлөөлж байна.